

# Манмин Мэдээ

Номер 28 2012 оны Арваннэгдүгээр сарын 4

## Агуу гайхамшигт эрх мэдэлт хүч чадлаар бүх дэлхийд тунхагладаг Өргөө сүм

Анхны цуглаан шиг олон тэмдэг гайхамшиг илчлэгдсээр...



Манмин төв сүм байгуулагдсанаас хойш библид бичигдсэн анхны цуглаан мэт тэмдэг гайхамшиг маш ихээр илчлэгдэн, сэргэлтээс сэргэлт рүү дэвжин ирсэн билээ. Бурханы бүтээлийн хүч нөлөө, амь, амьдралыг удирдан явуулж буй хүч нөлөө, цаг орон зайг үл хамааран нөлөөлөх хүч чадал, сүнсний орон зайг ашиглах гэх мэт хүч нөлөөгөөр дамжуулан үй олон хүмүүсийг авралын замаар удирдаж 10 мянга гаруй салбар сүм болон хамтарсан сүмүүдийг бий болгосон билээ.

Их Эзэний дахин амилалт болон тэнгэр өөд дээшлэн гарсаны дараа манай эриний 64 оноос эхлэн Ромын эзэнт гүрэн албан ёсоор христэд итгэгчдийг хавчиж эхлэх хүртэлх анхны цуглааны үнэхээр гайхалтай билээ. Ариун Сүнсний эрх мэдэлт хүчээр Бурханы сургаал номлолууд нь зөвхөн Иерусалимд, бүх Иудей, Самари болон бага Азийн орнууд, Грек болон Европ, дэлхийн соёл урлагын төв байсан Ромын эзэнт гүрэн хүртэл сайн мэдээ тунхаглагдаж, үй олон цуглаанууд бий болсон билээ.

Анхны цуглааны элч нар итгэгчдийн амиа зориулан байж сайн мэдээ идэвхитэй тараасаны эцэст манай эриний 313онд Ромын эзэн хаан Константин сайн мэдээг сонсч, Эзэнийг хүлээн авсан бөгөөд манай эриний МЭ 392 онд мөн Ромын эзэн хаан Теодосиус Христийн шашныг Ромын Хаант Улсын албан ёсны шашин болгон тунхагласан байдаг. Түүнээс хойш маш хурдан хугацаанд бүх дэлхий даяар сайн мэдээ эрчимтэй тараагдсан билээ.

Бурхан 1982 онд Манмин төв сүмийг босгон байгуулж, “Босч Гэрэлт” (Исаиа 60:1)-хэмээн айлдсан бөгөөд дэлхийн хязгаар хүртэл Эзэнийг гэрчлэгч болгохын тулд Манмин Төв Сүмд дэлхий дахинаа сайн мэдээ тараах үүргийг өгсөн билээ. Тэр цаг мөчөөс эхлэн гал мэт Ариун Сүнсний хүч нөлөө тасралтгүй бий болсоор ирсэн билээ.

Өнгөрсөн 30 жилийн турш Доктор И Жей руг Тэргүүн пастор ба итгэгчид энэ эцсийн үед сүнс зүгээр унтаж буй хүмүүсүүдийг сэрээж, мөхлийн замаар явж буй олон хүмүүсийг амьдруулахын төлөө амс хийлгүй урагшилсаар ирсэн билээ.

Үүний үр дүнд, Солонгосын орон нутаг даяар 43 салбар сүм ба 13 салбар танхим, гадаадад 10,000 гаруй салбар сүм болон хамтарсан сүмүүдийг бий болгосон анхны цуглаан мэт өсөж хөгжсөн юм.

Сүм байгуулагдаад 30 жилийн дотор энэ мэт асар хурдацтайгаар сэргэх болсон шалтгаан нь чухам юу вэ?

Сүмийн сэргэлт нь эцэстээ хүний хүчээр хийгддэг зүйл огтрон ч биш юм.

Шинэ гэрээний Үйлс номонд бичигдсэнчлэн элч Петр Эзэний тухай гэрчилэх үед ойролцоогоор 3,000 орчим хүмүүс цугларцаасан ба тэд бүгдээр тэр даруй гэмшиж байснаас гадна төрөл бүрийн өвчтэй хүмүүсийг эдгээж байсан бол элч Паулаар дамжуулан сайн мэдээ Ази болон Европ даяар дэлгэрч байсан нь тэсрэлт мэт Ариун Сүнсний хүч нөлөөгөөр л бий болгогдсон зүйл билээ.

Анхны цуглааны элч нар ба итгэгчид шиг Доктор И Жей руг Тэргүүн пастор нь Библи дээр суурилсан хүчит сургаал ба түүнд нь дагалдах тэмдэг гайхамшиг, эрх мэдэлт хүч чадлаар Бурханы амьдрал оршин байгааг баттайгаар нотлон харуулж байгаа билээ (Марк 16:20; Үйлс 2:22; Еврей 2:4).

Үүнээс гадна тэрээр 44 хэл дээр орчуулагдан гарсан христэд номууд ба 25 орны хэл дээр гардаг Манмин Мэдээ сонин, дэлхий өнцөг булан бүрт 170 гаруй оронд шууд цацдаг GCN ТВ,

Бурханы эрх мэдэлт хүчийг анагаах ухааны зүгээс баталдаг WCDN буюу ДХЭХ, (Дэлхийн Христэд итгэгч Эмч нарын холбоо), Манмин олон улсын библийн сургууль, ММБТ (Манмин миссионер бэлтгэх төв), болон долоо хоног болгон дэлхийн өнцөг булан бүрт болдог Номлогчдын Семинар болон Гар алчуурын цуглааны үйл ажиллагаануудаар дамжуулан үй олон хүмүүсийг өөрчлөлт болон мөнх амь руу хөтөлсөөр байгаа билээ (Үйлс 19:11-12).

Энэ мэт арвин их үр жимсийг боловсруулах хүртэл Өөрөө энэхүү цуглааныг босгон удирдаж, итгэлээ үзүүлэх тусам гайхалтай хариулт, ерөөлөөр хамтдаа байсан Гурвын холбооны Бурхандаа бүхий л талархал ба алдрыг өргөн барьж байна.

Цаашдаа дэлхий даяарх 7 тэрбум гаруй хүн төрөлхтөнийг жинхэнэ итгэлийг олохын тулд Манмин төв сүм нь тэсрэлт мэт Ариун Сүнсний хүч нөлөөн дотор Бурханы хүслийг биелүүлэхийн төлөө итгэлээрээ зогсолтгүй давших болно.

«Загалмайн Үг» цувралаас -(26)

# Ус болон Сүнснээс төрж байж л аврал хүртэнэ.

Есүс хариуд нь – “Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй гэхэд Никодем Түүнд -Настай болсон атлаа хүн хэрхэн төрөх билээ? Хүн эхийн хэвлийд хоёр дахиа орж, төрж чадна гэж үү? гэлээ. Есүс-Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” (Иохан 3:3-5).



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Бурхан Өөрийн цорын ганц Хүү Есүс Христийг энэ газар дээр илгэсэнээр хэн ч гэсэн Түүнд итгэн, хүлээн авсан хүн болгонд Бурханы хүүхэд болох эрх мэдлийг аван, мөнх амийг хүртэхийн тулд авралын замыг нээж өгсөн билээ.

Гэтэл өнөө үед олон хүмүүс Есүс Христийг хүлээн авсан Бурханд итгэдэг гэдэг ч эцэстээ аврал авна гэсэн баталгаагүйгээр итгэлийн амьдралаар амьдарч буй тохиолдол их байгаа билээ.

Энэ удаагийн дугаарт Есүс болон Никодем хоёрын хоорондох яриагаар дамжуулан ус болон сүнснээс дахин төрнө гэсэн үгийн утгын талаар ухаармагцаа төгс аврал гэж юу болох талаар авч үзэцгээе!

## 1. Есүс ба Никодем хоёрын яриан дахь сүнслэг утга

Никодем нь Иудей үндэстэн бөгөөд төрийн түшмэл, мөн зааж сургадаг багш, түүнчлэн Фарисей хүмүүсийн нэг бөгөөд хуулийг сайтар судласан хүн байв. Тухайн үед Фарисейчууд нь гадна төрх байдлаараа “ариухан” мэт харагдах боловч зүрх сэтгэлдээ үнэнийг гадагдаггүй хүмүүс байсан ба Есүсийн сургаалд итгэхгүйгээр үл барам Түүнийг хавчин тохуурхаж, хөнөөх гэж оролдож билээ.

Гэтэл Никодем нь бусад Фарисейчуудаас өөр байсан ба үнэн зөвийг эрэн хайдаг, ухаарч жинхэнэ итгэлийг олж авахыг хүсдэг нэгэн байсан тул нэгэн шөнө Есүс ирэн уулзсан билээ. Есүстэй уулзсаны дараа Никодемийн үйлсийг ажиглавал Фарисейчууд Есүсийг хавчин буруутгах үед Есүсийг өмгөөлдөг байсан ба (Иохан 7:50-51), ба Есүсийг загалмайн дээр цовдлогдон нас барсаны дараа тэрээр, “мирр, алоены зуун литра хольцыг” авч ирж байсан юм (Иохан 19:39). Эндээс үзэхэд бид Никодемийг аврал хүртэх хэмжээний итгэлтэй болсон талаар мэдэх боломжтой юм.

Никодем нь Есүст, хандан “Рабби, Таныг Бурханаас ирсэн Багш гэдгийг бид мэднэ. Учир нь Бурхантай хамт байхгүй л бол, хэн ч таны үйлддэг тэмдгүүдийг үйлдэж чадахгүй” чин сэтгэлээсээ

хэлдэг билээ.

Есүс түүний зүрх сэтгэлдээ үнэнийг эрж хайж буй сэтгэлийг мэдээд, “Үнэнээр үнэнээр Би чамд хэлье, Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй” хэмээн сүнс зүгийн утга бүхий үг айлдсан юм. Үүнийг сонссон Никодем нь хэдийн эхийн хэвлийгээс төрөөд, өсөж бойжсон хүн яаж дахин төрөх талаар, заавал дахин төрөх ёстой талаарх Есүсийн үгийг огт ойлгохгүй байлаа.

Бурханы хүн гээд сургаалийн талаарх ухаарал байхгүй бол Бурханы амьд оршин буй хүч нөлөө мэдрэх боломжгүй бөгөөд итгэгч нарын итгэл өсөхгүй, сүм сэргэхгүй зогсонги байдалтай байх юм. 1 Коринт 4:20-д, “Учир нь Бурханы хаанчлал үг яриан дотор бус, харин хүч дотор байна” хэмээн айлдсан байдагчлан Ариун Сүнсний бялхал дотор Бурханы хүч чадлыг хүлээн авч байж л тухайн үгэн доторх сүнслэг утга нууцыг ухаарч, Бурханы хүслийг агуу ихээр биелүүлэх боломжтой билээ.

Ийм сүнс зүгийн утга бүхий Есүсийн үгийг ойлгож чадаагүй Никодем нь “Настай болсон атлаа хүн хэрхэн төрөх билээ? Хүн эхийн хэвлийд хоёр дахиа орж, төрж чадна гэж үү?” хэмээн дахин асуудаг.

Тэгтэл Есүс түүнд “Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй. Махан биеэс төрсөн нь махан бие, Сүнснээс төрсөн нь сүнс болой. “Чи дээрээс төрөх ёстой” гэж Би чамд хэлсэнд бүү гайх. Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хаашаа оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг” гэж хариулсан билээ.

Хүн тэнгэрийн оронд орохын тулд нүдээр харагдахгүй сүнс нь дахин төрөх ёстой гэсэн үг юм. Хүн төрөлхтөний эцэг өвгөд болох Адам нь амьд оршигч болон бүтээгдсэн боловч гэм үйлдсэнээс болж сүнс нь үхмэл болсон билээ. Түүнээс хойш Адамын үр удам ч сүнс нь үхмэл, махан биеэр төрсөн боловч бүх хүн төрөлхтөний сүнс нь үхмэл болсон тул Тэнгэрийн орон руу орох боломжгүй бөгөөд эцэст нь там, өөрөөр хэлбэл мөхлийн замаар явахаас өөр аргагүй байсан учраас ус ба сүнснээс дахин төрж байж л Тэнгэрийн орон руу явах боломжтой билээ.

Тиймээс Есүс “Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хаашаа оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг” хариулсан ба салхийг харах боломжгүй болон түүний чиглэлийг хаанаас ирээд хаашаа явдагыг мэдэх боломжгүйгээ адил Сүнсний ертөнцийн үйл явдалыг зөвхөн Бурханы хүч чадал болон Ариун Сүнсний хүч нөлөө, бялхал дотор байж л олж мэдэх боломжтой билээ.

## 2. Усаар дахин төрөх гэдгийг сүнслэг утга

Тэгвэл Есүсийн айлдсан шиг хүний сүнс ус болон Сүнсээр дахин төрнө гэдэг нь ямар утгатай

бэ?

Эхлээд ус гэдэг нь Иохан 4:14-д, дурдсанчлан Есүсийн өгдөг “мөнх аминд хүртэл оргилох булаг” гэсэнтэй адил утгатай юм.

Тэгвэл, “мөнх аминд хүртэл оргилох булаг өөрөөр хэлбэл Есүсийн өгдөг мөнхийн ус гэж юу вэ? Энэ нь Хүний Хүү өөрөөр хэлбэл Есүс Христийн махыг идэж, цусыг уухгүй л бол бидний дотор мөнх амь байхгүй” хэмээн айлдсан байдаг (Иохан 6:53). Хүний Хүүгийн махыг идэх гэдэг нь Бурханы үгийг сонсоод өөрийн болгон хүлээн авахыг хэлж байгаа бол, Хүний Хүүгийн цусыг уух гэдэг нь Бурханы үгийг өөрийн амьдралдаа итгэлээрээ хэрэгжүүлэхийг хэлж байгаа билээ. Ингэж Хүний Хүүгийн махыг идэж, цусыг ууснаар эцэстээ энэ Бурханы үг нь хүнийг мөнх аминд хүргэх амийн усны үүргийг гүйцэтгэж байгаа юм.

Ус нь бохир зүйлсийг угаан цэвэршүүлж, бүх амьд биет болон түмэн бодис амь ба тэжээл болж өгдөг шиг сүнслэг утгаараа ч ус нь-Бурханы үгийг илэрхийлдэг бөгөөд бидний зүрх сэтгэл дэх атгаг хорон муу байдлыг ариутган цэвэрлэж мөнхийн амьдралыг олж авахад тусалдаг билээ. Зүрх сэтгэлд буй гэмт зан чанар, атаархал, үзэн ядалт, уур хилэн зэргийг Бурханы үгээр цэвэрлэх үед л дахин төрөн аврал хүртэх болдог. Тиймээс 1 Петр 3:21-д, “Ус бол Есүс Христийн амилталтаар дамжуулан одоо та нарыг аврах бэлэг тэмдэг болох баптисм юм. Энэ нь махан биеийн бузрыг арилгадаг биш харин сайн мөс чанараар Бурханд хандан өргөх амлалт юм” хэмээн айлдсан байдаг.

Тиймд бидний гэм нүглийг угааж өгдөг ус болох Бурханы үгийг зүрх сэтгэлдээ хүлээн аваад, түүнчлэн үйлдэх үед аажим аажмаар ариун нэгэн болдог бөгөөд энэ нь аврал хүртэх баталгаа мөн.

## 3. Ариун Сүнсээр дахин төрнө гэсэн үгийн сүнслэг утга

Ариун сүнс нь ариухан Бурханы сүнс бөгөөд бүхий л аврал хүртсэн үр хүүхдүүдийн зүрх сэтгэлд бууж ирсэнээр төгс авралд хүрэх хүртэл тусалж өгдөг. Иохан 15:26-д дурдсан шиг, “Би Эцэгээсээ та нар уруу Туслагчийг илгээнэ. Тэр бол Эцэгээс гарах үнэний Сүнс мөн. Тэр ирэхдээ Миний тухай гэрчилнэ.” хэмээн айлдсаны дагуу Эзэн дахин амилж дээш одсоны дараа Бурхан аврал хүртсэн үр хүүхдүүддээ Ариун Сүнсний бэлгээр өгч, (Үйлс 2:38) үхмэл сүнсийг нь амилуулж, итгэх итгэлийг авах хүртэл тусалж өгдөг билээ.

1 Иохан 5:5-8-д, “Есүс бол Бурханы Хүү мөн гэж итгэдэг хүнээс өөр хэн ертөнцийг ялагч байх вэ? Энэ бол ус ба цусаар ирсэн нэгэн буюу Есүс Христ юм. Тэр зөвхөн усаар биш, харин ус ба цусаар ирсэн. Гэрчлэгч нь Сүнс юм. Учир нь Сүнс бол үнэн мөн. Гэрчлэгч нь гурав бөгөөд Сүнс, ус болон цус юм. Энэ гурав нь нэг болой.” хэмээн дурдсан байдаг.

Энд Есүс Христ “ус ба цусаар ирсэн” гэдэг нь

ус болох үг нь махан биеийг өмсөн ирсэн Есүс ариун цусаа урсган бидний төлөө үхсэнийг хэлж байгаа юм. Есүс загалмайн дээр цовдлогдсон учраас, бид Түүний ариун гэм зэмгүй цусаар хүчийг олж авралд хүрдэг билээ. Тиймээс, “ус ба цусаар ирсэн Нэгэн” гэдэг нь Есүс Христ бөгөөд Эзэн дээш одсоны дараа илгээж өгсөн Ариун Сүнс нь бидэнд энэ үнэнийг мэдүүлж баттай итгэхэд тусалдаг билээ.

Есүсийг Бурханы Хүү гэдэгт итгэдэг хүн нь “дэлхийг ялсан” гэсэн байдаг ба энэ нь дэлхийн зүйлд шунаж хүсэх сэтгэлтэй тэмцэж, ялснаар гэм үйлдэхгүй, худал хуурмаг зүйлтэй хутгалдахгүй байх талаар хэлж байгаа юм. Ариун Сүнс нь бидэнд Эзэнд багтай итгэх итгэлийг олж авахад туслах төдийгүй гэм нүгэл ба зөвт байдал, шүүлт тухай ухааруулж өгдөг тул бид хангалттай энэ дэлхийг ялан дийлж чадах хүчийг өгдөг билээ. Ариун Сүнсний хүч нөлөөн дотор гэм нүгэл гэж юу болох мэдээд, бидний биелүүлэх ёстой зөвт байдлыг ч мөн ухаарч, шүүлтийн талаар үнэхээр итгэдэг бол мэдээж Ариун сүнсний хүслийг даган амьдрах болдог. Өдөр бүрийн амьдралдаа өөрийн зүрх сэтгэлээ хянаж, гэмт чанарууд илрэх бүрт хаяснаар, эцэстээ үнэний сэтгэлээр өөрчлөгдөх болно.

Энэ нь Ариун Сүнсээр дамжуулан сүнснийг дахин төрүүлэх үйл явц бөгөөд ус болон сүнсээр дахин төрж, Ариун Сүнсээр сүнснийг бий болгож буй хүн л Бурханы улсад орох боломжтой билээ.

Хайрт итгэгч та бүхэн минь, Ефес 2:8-д дурдсан шиг, “Учир нь нигүүлсээр та нар итгэлээр аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд” хэмээн айлдсан байдаг. Хүн ус болон Ариун Сүнсээр дахин төрөх боломжыг ч гэсэн, мөнхийн амьдрал хүрэх нь ч гэсэн зөвхөн Бурханы Аавын хайраар бий болсон зүйл бөгөөд бидэнд ямар ч үнэггүйгээр өгсөн бэлэг билээ.

Тиймээс, бид авралын замаар удирдаж буй Бурхандаа талархан, үй олон хүмүүсийг тэнгэрийн орон руу удирдах хэрэгтэй билээ. Хамгийн үзэсгэлэнтэй тэнгэрийн орон болох Шинэ Иерусалимд орох итгэгч нар болохыг мөнхийн Эзэн Есүс Христийн нэрээр хүсэн ерөөе!

Mongolian

## Манмин Мэдээ


Published by Манмин Төв Сүм

---

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
<http://www.manmin.org/english>  
e-mail: [manminministry@hotmail.com](mailto:manminministry@hotmail.com)  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин

### Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг		Залбирлын цаг		
Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Их мөргөл	Ням гариг 10: 30	Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40			
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00	Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00			
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30			
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30	Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С

**Утас:** чуулганы- 5525-7637  
чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
www.manmintv.org

# “Сүнс” болох Бурханы зүрх сэтгэлийг мэдрэгч гайхалтай агшин!

2012 оны Манмин Сүмийн Эрэгтэй, Эмэгтэйчүүдийн багийн зуны цуглааны үйл ажиллагаанд гадаадын нийт 23 Орны гишүүд оролцов.



Спортын тэмцээн



Сонотой хамт байх цаг



Галын наадам ба Магтаал хиндэтгэлийн наадам

2012 оны 8-р сарын бны өдөр, “Манмин сүмийн Эрэгтэй, Эмэгтэйчүүдийн багийн Зуны цуглааны үйл ажиллагаа” Жонбуг мужын Мүжү хэмээх газарт орших Догюусан амралтын газарт болж өнгөрлөө. Итгэгчид хоёр шөнө, гурван өдрийн турш болж өнгөрсөн энэхүү үйл ажиллагааны төрөл бүрийн хөтөлбөрөөр дамжуулан Сүнс болох Бурханы тухай суралцан итгэлээ өсгөсөн юм.

Сөүл, Дейжон, Пусан, Гуанжу, Гуми, Масан, Чунчеон ба Чезү зэрэг орон нутгын хотууд төдийгүй, гадаадаас АНУ, Герман, Швейцарь, Франц, Кени, Япон, Хятад болон Тайвань зэрэг нийт 23 орны номлогч нар болон итгэгчид 300-гаад хүн оролцсон олон улсын хэмжээний үйл ажиллагаа болж өнгөрөв. Ялангуяа Тайланд, Малайз болон Фаруже арлаас ирсэн 50 хөгжлийн бэрхшээлтэй итгэгчид оролцсон онцгой үйл ажиллагаа болж өнгөрлөө.

Эхний өдрийн номлолын цагаар Манмин Залбиралын төвийн ахлагч И Бугним нь 2 Коринт 2:14-16-д ишлэлээр “Үзэсгэлэнтэй зүрх сэтгэлийг бий болгох нь” гэсэн сэдвээр сургаал заасан ба үүгээрээ дамжуулан сүнсний сэтгэлийг бий болгох арга замын талаар дамжуулсан юм. “Гэм нүгэл ба хорон санаа, худал хуурмаг, харанхуй зэрэг сэтгэл дэх өргөс мэт зүйлийг авч үзэсгэлэнтэй сүнсний

сэтгэлийг бий болгохын төлөө тэмүүлж, шийдвэртэйгээр зүтгэх хэрэгтэй талаар” онцгойлон дурдсан юм. Мөн түүнчлэн, үүний хамт гал мэт халуунаар залбирлаар өөрийгөө өөрчлөхөд тэр хэмжээний тэвчээр хэрэгтэй талаар тайлбарлан, түүний бялхам дүүрэн магтаал ба залбирлаар үргэлжилсэн юм.

Эдгээр үйл ажиллагааны дараа “тэнгэр, од ажиглах” үеэр гайхамшигт зүйл болж өнгөрлөө. Тэр орой маш үүлэрхэг байсан ч яг цуглааны үйл ажиллагаа болж байсан газрын дээр үүл ярагдан нээгдэж, үй олон гялтганах оддоог харах боломжтой болсон билээ. Мөн олон янзын хиймэл дагуулууд болон байрнаасаа хөдлөн бүжиглэх мэт ододын хараад энэ мэт байгалийн үзэсгэлэнт байдлаар хамт байсан Бурханы хайранд талархаж байлаа.

Зуны цуглааны хоёр дахь өдрийн үдээс өмнө спортын уралдаан тэмцээн нээлтээ хийсэн юм. Анх удаагаа их тойрог, бүсчилэлээрээ хуваагдаж уг тэмцэнд оролцоход итгэгчид үүнд ихэд анхаарлаа хандуулан 1-р, 2-р, 3-р их тойрог, Салбар сүмүүд ба гадаад итгэгчид нэгдэн нийт 4 баг болон хуваагдан оролцогдов.

Нээлтийн үйл ажиллагаа нь Доктор И Жей руг пасторын залбирлыг бичлэгээр сонсож, үргэлжлүүлэн И Сү жин пастор тэмцээний

анхны гарааг бөмбөг өшиглөн тэмцээнийг эхлүүлэв. Тэмцээн нь 10 төрлөөр бөмбөгөөр дүүргэх, 100м-ийн гүйлт, холын зайн гүйлт, багаар дээс тоглох, байт бөмбөг өшиглөх, хөл бөмбөг, Воллейбол, Агаарын теннис, олс татах, буухиа гүйлт зэрэг тэмцээнүүд явагдав. Уралдаанд оролцогчид нийт 14 алтан медалийн төлөө өрсөлдцөгөөв.

Тэмцээн болгон маш өрсөлдөөнтэй болж байсан бөгөөд баг тус бүрийн хөгжөөн дэмжигчдийн тусгай үзүүлбэрүүд тэмцээнийг улам ч хөгжилтэй өрсөлдөөнтэй болгож байлаа. Тэмцээний дүн гарч, тэргүүн байрыг нийт долоон алтан медаль авсанаар 2-р их тойргийн баг авсан ба мөн шилдэг эрэгтэй, эмэгтэй тоглогчдоор 2-р их тойргийн баг, Кан Сун хее сүмд үйлчлэгч, болон Ча Сү хяан сүмд үйлчлэгч нар тодорхойлогдов.

Мөн тэр өдрийн орой номлолын цагт Магтаал дуу бүжгийн хорооны ерөнхий удирдагч И Хи жин пастор Иохан 4:24-д ишлэлийн дагуу “Сүнс” хэмээх сэдвээр сургаал айлдсан бөгөөд тэрээр “Сүнс бол Бурхан Аавын зүрх сэтгэл бөгөөд бүх сайн сайхны уг үндэс, ба хайр энэрэл юм” хэмээн айлдсан юм. Мөн бид “Тэр бүл, хамаатан садан, найз нөхөд, хамт олноо хэр зэрэг ойлгож өгдөг, хайраар зориулж өгдөг талаар, мөн хэр зэрэг Бурханыг

сэтгэлдээ агуулан, сайн ба хайраар үйлчилдэг болохоо эргэн харан, өөрсдийн итгэл болон сүнслэг сэтгэлийн аль хэмжээнд явц буй” талаар тайлбарласан билээ. Номлолын дараа үргэлжлүүлэн гэмшлийн залбирал ба Ариун Сүнсээр дүүрэх залбирлын цуглаан болж өнгөрлөө.

Түүний дараа, Эрэгтэй Эмэгтэйчүүдийн багийн ерөнхий удирдагч болох И Хи сон пасторын удирдсан Галын наадам ба магтаалын цуглаан ивээлээр бялхам дүүрэн явагдаж, баярын салот буудан, Бурхан Аавдаа алдрыг өргөж байлаа. Манай төв сүм төдийгүй солонгосын орон нутгын болон гадаадын бүх итгэгч гишүүд Бурханы хайраар хамтдаа нэгдэцгээсэн, сэтгэл хөдлөм хором байлаа.

Зуны цуглааны бүх үйл ажиллагаа И Жей руг пасторын залбирал хийж өгсөнчлөн, таатай сэрүүхэн цаг агаарт ивээл дүүрэн болж өнгөрсөн юм. Энэ жил ч мөн үй олон тооны сононууд бууж ирэн, итгэгчдийн нүүр, гар, мөр, зэрэг дээр нисэн ирж суун бидэнтэй хамт буй Бурханы хайрыг мэдрүүлж байлаа. Талархал ба баяр хөөр, Тэнгэрийн орны хүсэл тэмүүлэл бялхам дүүрэн зуны цуглаанаар дамжуулан ивээл ба сэтгэл хөдлөлийг өгсөн Бурхандаа бүхий талархал ба алдрыг өргөн барья!

## Улаанбаатар Манмин Сүм

### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

### Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57-тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com



Өнгөрөгч 2012 оны Зургадугаар сарын 21-нд, Би сүмийнхээ магтаал дуу хөгжмийн хороонд харьяалагдах “Тэнгэрийн бүжиг” багийн тусгай тоглолтын бэлтгэл хийж байв. Бэлтгэлийн явцад би Сугу (Солонгосын үндэсний бөмбөр мэт бариулгүй хөгжмийн зэмсэг) гэдэг хөгжим барин бүжиглэх үедээ хамраа цохиж бэртээсэн билээ.

Яг тэр үед миний нүдний нулимс урсаж, хамар маш хүчтэй шархиран өвдөж эхлэн, хамраас маань маш их цус зогсолтгүй олгойдон гарч байлаа. Хамрынхаа цус гарч байгаа хэсэгт нэг бүтэн ариун цэврийн цаасаар бөглөн дарж байхдаа гар утсаар дамжуулан И Жей руг тэргүүн пасторын автомат хариултын үйлчилгээнд холбогдон бичлэгээр “Өвчний төлөөх залбирал” авсан юм. Залбирал авч дуусмагц хамраас гарах цус тэр даруй зогсч, маш хүчтэй өвдөлт ч ор мөргүй алга боллоо. Мөн гайхалтай нь энэ бэртлээс болж хамрын гадна талд нь ямар нэг шарх сорви юм уу булуу мэт зүйл үүсээгүй юм.

## “Хамрын ясны бэртэлийг Бүтээгч Бурханы эрх мэдэлт хүчээр маш хурдан эдгэрсэн билээ”

Пин Жина Эгч дүү (1-р Оюутны баг)

Тэгээд би хамрын гэмтлийг тодорхойлохын тулд нэгэн Их сургуулийн эмнэлэгийн хүлээн авахад очиж рентген зураг, болон Эхо аппаратын шинжилгээ хийлгэсэн ба хамрын гурвалжин мөгөөрс хүнд гэмтсэн байдалтай байсан ба эмч надад хэлэхдээ яаралтай хагалгаа хийлгэх шаардлагатай хэмээн хэлэв. Мөн хагалгаа хийхдээ хэсэгчлэн мэдээ алдуулалт хийж, хагалгааны дараа 1сар орчим хамрын ясыг барьж байх тулгуур бэхлэгээ зүүх ба үүний улмаас хамраар амьсгалахад хүндрэл учирч болзошгүй гэж эмч надад эмчилгээний үйл явцыг тайлбарлаж өгөв.

Энэ хугацаанд би Бүтээгч Эзэн Бурханы эрх мэдэлт хүч чадлыг харан итгэлийн амьдралаар өдий хүрсэн бөгөөд мөн автомат хариултын үйлчилгээний “Өвчний төлөөх залбирал” авсаны дараа хамарт минь ямар нэгэн хүндрэл мэдрэгдээгүй үл ялиг хавдсан байсан ч Эдгээгч Ёхова Бурхан миний хамрыг төгс болгож өгнө гэдэгт итгэж байлаа. Тиймээс ч би И Жей руг тэргүүн пасторын залбиралыг авсан юм. Маргааш өдөр нь гэхэд л хамрын хавдсан хэсэг бүрэн арилсан байлаа.


2012 оны Долдугаар сарын 3-нд, би товлогдсон хөтөлбөрийн дагуу багийнхантайгаа хамт тоглолтондоо орж ямар ч саадгүй бүжиглэн Бурхан Аавдаа алдрыг өргөсөн юм. Тэгээд маш их завгүй байсан учраас эмнэлэгт ч үзүүлэх боломжгүй байсаар 2012 оны Долдугаар сарын

27-нд дахин эмнэлэгт очин рентген зураг, болон Эхо аппаратын шинжилгээ хийлгэсэн ба шинжилгээний хариу нь хамрын гурвалжин мөгөөрс ямар ч гэмтэлгүй хэвийн болсон байгааг олж мэдсэн юм. Халлелүяа!

Бурхан миний итгэлийг хараад ихэд баярлан таалж, Бүтээгч Бурханы эрх мэдэлт хүч чадлаар асар хурдан эдгээж өгсөн юм. Тэр ч байтугай өмнөхөөс ч илүү эвтэйхэн хөөрхөн хэлбэртэй богож өгсөн учраас үнэхээр их талархаж байна. Ариун Гурвал Бурхандаа бүхий алдар ба магтаалыг өргөн, миний төлөө залбирал хийж өгсөн И Жей руг тэргүүн пасторгаа талархсанаа илэрхийлье.



▲ Эдгэрэхээс өмнө:  
Хамрын мөгөөрс  
гэмтсэн байдал



▲ Эдгэрсэний дараа:  
Гэмтсэн хэсэг  
хэвийн болсон  
байгаа байдал

## “Төөрөлдөж байсан намайг ариун замаар удирдаж буй Эзэн минь, Үнэхээр их талархаж байна”

Сурияанонти Сомчай бэлтгэл номлогч (Тайланд хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн Суратани Манмин сүм)

Би Хятад аав Индонези ээжээс төрөлхийн сонсголгүй төрсөн юм. Би мөн холимог үндэстэн эрлийз хүүхэд тул багадаа маш хүнд хэцүү зүйлүүдтэй тулгардаг байсан ба мөн аав маань маш олон эмэгтэйтэй уулздаг байсан учир хэвийн гэр бүлд өсөх боломжгүй байсан бөгөөд би 3 хойд ээжийн нүүр үзсэн юм. Би өөрийнхөө ээжийг ямар хүн байсныг мэдэхгүй билээ.

Ийм нөхцөл байдал дотор өсөж торнисон би ямар нэг зүйлд найдах зүйл байхгүй болж, нэг л мэдэхэд аав шиг адилхан хэрэн тэнэдэг хүн болсон байлаа. Би 19 настайгаасаа эхлэн сүмд явж эхэлсэн боловч чин сэтгэлийн итгэл байхгүй тул үргэлжлүүлэн замбараагүй амьдралаар амьдарсаар л байв. Тэр хавьдаа бүүр танил болсон замбараагүй хүүхэмсэг хүн байлаа.

2010 оны 1-р сард юм. Тэр үед би Тайландын Хат яа мужын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонд ажиллаж байхдаа Манмин төв сүмийн хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн хэсгийн дэд удирдагч, Малайзид Сайн мэдээ тараахаар илгээгдсэн Жи Жонхун номлогчтой танилцаж, мөн Манмин төв сүмд болдог агуу гайхамшигтай гэрчлэлүүд болон эрх мэдэлт хүчний үйлсийн талаар надад танилцуулсан юм.

Мөн би Жи номлогч дамжуулан Жозеф Лимбанпил бэлтгэл номлогч (Тайланд Хатяагийн хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн Манмин цуглааны хариуцагч)-той танилцаж тэдгээр дамжуулан И Жей руг тэргүүн пасторын сургаал үг болон Бурханы эрх мэдэлт хүчний тухай үргэлжлүүлэн хүлээн авч байлаа. Доктор И Жей руг тэргүүн пастор айлдахдаа “Өвчний төлөөх залбирал”-ыг итгэлээрээ залбирал авбал цаг орон зай үл хамааран нөлөөлж эдгэрэх боломжтой гэж айлдсан билээ.

2010 оны Дөрөвдүгээр сард, би Жи номлогч болон Жозеф номлогч нартай дахин уулзав. Жозеф номлогч надад тайлбарлан Доктор И Жей руг тэргүүн пасторын “Там” номын талаар танилцуулсан билээ. Тэр номонд буй сургаал надад том цохилт болсон ба олон зүйлийг ухаарч,

тэр 2 номлогчдын зөвлөгөөг сонсож, садар самуун явдлаа хаяж, дахин шинэ амьдрал эхлэхээр сэтгэлдээ шийдсэн юм. Тэгээд эхлээд 1 өдөр мацаг барин, өнгөрсөн амьдралаа эргэн харан чин сэтгэлээсээ гэмшсэн юм.

Үүний дараа, би Хатяа Манмин Сүмд явдаг болсон ба 2 сарын турш өдөр бүр нэг удаагийн хоол идэлгүй Бурханы үгийн дагуу амьдрахын тулд хичээж байлаа. Доктор И Жей руг тэргүүн пасторын ном болох “Загалмайн Үг” хэмээх номыг уншаад би “Бурхан яагаад сайн мууг мэдүүлэгч модыг тавьсан учир”, “Зөвхөн Есүс яагаад бидний аврагч болсон” зэрэг авралын төлөвлөгөөг ухаарсан учир итгэлийн амьдралд минь маш их өөрчлөлийг авчирсан юм. Түүнчлэн би өдөр бүр оройн залбиралд оролцон залбирахад миний үг хэллэг болон үйлдэл, зан байдал маань өөрчлөгдөв.

2010 оны Зургадугаар сард болон 2012 оны Тавдугаар сард Солонгосын Манмин төв сүмийн Чу Су ёол пастор Тайландад хүрч ирэн И Жей руг тэргүүн пасторын залбирал хийж өгсөн гар алчуурын залбирлаар (Үйлс 19:11-12) дамжуулан амьд оршигч Бурханыг гэрчилж байсан юм. Олон хүмүүс өвчнөөсөө эдгэрч Бурхандаа алдрыг өргөсөн бөгөөд эдгээрээр дамжуулан би итгэлээ өсгөх боломж олдсон ба олон хүмүүсийг авралд хүргэх сайн мэдээг тараах үүргийг хүлээн авахын эхлэл болж өгсөн юм.

2012 оны Наймдугаар сарын 3-нд, Малайзи болон Тайланд улсын хөгжлийн бэрхшээлтэй итгэгчидтэйгээ хамтдаа “Манмин Эрэгтэйчүүд Эмэгтэйчүүдийн багийн нэгдсэн зуны цуглаан”-д оролцохоор Солонгост 2 дахь удаагаа ирсэн билээ. 2010 онд анх Манмин төв сүмд ирэхэд төрсөн сэтгэгдэл минь Бурханы эрх мэдэлт хүч чадалба Эзэний хайраар дүүрэн, аз жаргалтай орчин намайг угтсан юм.

Тухайн үед, би анх удаагаа И Жей руг тэргүүн пасторыг харсан бөгөөд хайр ихтэй дулахан эрхэм байсан яг л миний аав мэт санагдсан билээ. Аав ээждээ хаягдсан,

шоовдор нэгэн гэсэн бодол ба зовиур дотор амьдарч байсан миний сэтгэл энэ үед цас хайлах мэт үгүй болсон юм. Тиймд Бурхан миний Аав болж, тэрхүү Аавын хайрыг Доктор И Жей руг тэргүүн пастораар дамжуулан мэдрэх боломжтойд баяр хөөр ба талархалаар дүүрэн байна.

2012 оны Зуны цуглааны үйл ажиллагаа ч ивээл ба үнэнээр дүүрэн цаг байлаа. Ялангуяа Марагийн тэмдэг шиг (Египетээс гарсан нь 15:25) далайн шорвог ус уух боломжтой амтат ус болон хувирсан Мүан амтат усны хүрээлэнд очоод гайхалтай мэдрэмжийг авсан юм. Мүан амтат усанд булгах үед Бурхан сүнсний нүдийг нээж өгөн тэнгэрийн орны үзэсгэлэнтэй эрдэнэсийг харсан юм.

Одоо би сэтгэлдээ нандин эрдэнийг аваад буцаж байна. Үзэсгэлэнтэй эрдэнэс мэт Бурхан Аав ба Эзэний хайраар гэрэлтсэн хүсэл тэмүүлэл дүүрэн урагшилах болно. Халлелүяа!

